

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ТАЙЛАН

Нийслэлийн Түргэн Тусламжийн Төвийн "Гэрээт харуул хамгаалалт"-ын үйлчилгээг үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны тайлан

Нийслэлийн Түргэн Тусламжийн Төвийн захирлын 2016 оны 4-р сарын 06 өдрийн А/14. тоот тушаалаар батлагдсан "Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх" НТТТВ /НТШ/02 тоот тендерт оролцогчдоос гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, тендерийн үнэлгээний хороог тус төвийн нягтлан бодогч А.Доржсүрэнжанцанхорлоо, засварын механикч З.Орхонсүрэн, программист С.Бямбасүрэн, аж ахуйн нярав Ю.Буянхишиг, хөндлөнгийн гурван гишүүнээр НЭМГ-ийн мэргэжилтэн Д.Баярмаа, ХАҮАГ-аас санал болгосон ТББ-ын мэргэжилтэн Т.Ангирмаа, А.Уламбаяр нарын 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Тендерийн Үнэлгээний Хороо Тендерийн бичиг баримт техникийн тодорхойлолтыг ажлын бус цагаар боловсруулж, 2016 оны 4-р сарын 11-ний өдрийн хурлаараа тус ТББ болон урилгыг баталж, 2016 оны 4-р сарын 12-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох өдөр тутмын хэвлэл "Өдрийн сонин" болон НТТТ-ийн веб хуудсанд тендерийн урилгыг зарлан нийтэлсэн болно. Мөн www.eprocurement.gov.mn веб хуудсанд урилгыг нийтэлсэн болно.

Тендерийн хүлээн авах хугацааг 30-аас доошгүй хоног байхаар тооцож 2016 оны 5-р сарын 12-ны өдөр тендерийг хүлээн авахаар тогтоосон. Тендерийн бичиг баримтыг "Гэрлээр тэтгэгч" ХХК, "Ирвэс секьюрити" ХХК, "Бууч гранд" ХХК, "ТДЕ" ХХК, "Бүрэн дуулга" ХХК, "Пүүл Макс" ХХК, "Тольтын гол" ХХК тус бүр 50 000 /тавин мянган/ төгрөгөөр худалдан авсан.

Тендерийн нээлтийг товлосон хугацаа буюу 2016 оны 5-р сарын 12-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө "Ирвэс секьюрити" ХХК, "ТДЕ" ХХК, "Бүрэн дуулга" ХХК, "Тольтын гол" ХХК болох 4 компани тендерийн материалаа ирүүлсэн. Харин ТББ худалдан авсан "Гэрлээр тэтгэгч" ХХК, "Бууч гранд" ХХК, "Пүүл Макс" ХХК болох 3 аж ахуйн нэгж нь тендерийн материалаа ирүүлээгүй болно.

Тендерийг нээлтийг 2016 оны 5-р сарын 12-ны өдрийн 10 цаг 30 минутанд нээсэн болно. Тендерийн нээлтэнд дээрхи 4 компанийн төлөөллийг байлцуулан, тендерийн материал ирүүлсэн дарааллаар нь ТББ-уудийнх нь лац тэмдэгийг шалган задалж, тендерийг нийтэд зарлан мэдээлэхэд дараахи үнийн саналыг ирүүлсэн байна. Үүнд,

№	Тендерт оролцогчдын нэрс	Үнийн санал/ төг	Үнийн хөнгөлөлт/төг
1.	"Ирвэс секьюрити" ХХК	60 000 000	Байхгүй

2.	"Тольтын гол" ХХК	85 500 000	Байхгүй
3.	"Бүрэн дуулга" ХХК	52 110 000	Байхгүй
4.	"ТДЕ" ХХК	7 725 000	Байхгүй

болно.

Оролцогчид бүгд хуульд заасны дагуу Тендерийн маягт баталгааг харилцагч банкуудаараа гаргуулан ирүүлсэн байна. Тендерийн нээлтийн ажиллагааг маягт 5-ын дагуу хөтөлж оролцогчдын төлөөлөгчид болон үнэлгээний хорооны гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай МУ-ын хуулийн 27-р зүйль, тендерийг хянан үзэх заасны дагуу оролцогчид захиалагчийн тогтоосон ерөнхий болон санхүүгийн чадавхи, техникийн тодорхойлолт бусад нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг хянан үзсэн. Сангийн сайдын 2012 оны 194-р тушаалын 3-р хавсралтаар батлагдсан Тендерийн үнэлгээний зааврын дагуу тендер шалгаруулалтын маягтуудыг байгууллага бүрээр дүгнэн шалгаж, үнэлгээний хорооны гишүүд бүр саналаа өгч тайланд тусгасан.

Тендерт оролцогчдын ТББ-ийн бүрдэл, үнийн санал, техникийн үзүүлэлт бүртэй нэгбүрчлэн танилцаж, бүгдэд харьцуулсан дүгнэлт гаргасан. Гишүүд тендерийн үнэлгээний дүнг үзүүлэлт бүрээр хэлэлцсэний үр дүнд доорхи дүгнэлтийг гаргасан.

САНАЛ ДҮГНЭЛТ

1. Тендерт оролцогч "Бүрэн дуулга" ХХК, "Ирвэс секьюрити" ХХК ирүүлсэн тендерүүдийг захиалагчийн шаардлагад нийцсэн тендер гэж үнэлэх
2. "ТДЕ" ХХК, "Тольтын гол" ХХК ирүүлсэн тендерүүдийг захиалагчийн шаардлага хангаагүй тендер гэж үнэлэх
3. Тендерийн материал техникийн үзүүлэлтүүд нь захиалагчийн тавьсан шаардлагыг хангаж байгаа "Ирвэс секьюрити" ХХК-ийн тендерийг хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгаруулж НТТТ-д "Гэрээт харуул хамгаалалт" –ын үйлчилгээг үзүүлэх гүйцэтгэгчээр сонгох, хэлцэл хийх
4. Хамгийн бага санал ирүүлсэн боловч техникийн тодорхойлолтыг хангаагүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.1-р зүйл тендер нээсний дараа тендер тус бүр нь дараахь шаардлагыг хянан үзнэ. 27.1.2 техникийн тодорхойлолт хангалтгүй гэж үзэх "Бүрэн дуулга" ХХК –ийн тендерээс татгалзах

Тендер ирүүлсэн байгууллага бүрт албан бичгээр мэдэгдэл хүргүүлэх

Үнэлгээний хорооны тайлан, хурлын тэмдэглэлтэй танилцсан,

Үнэлгээний хорооны дарга

/...../

А.Доржсүрэнжанцанхорлоо

Гишүүд

/...../

З.Орхонсүрэн

/...../

С.Бямбасүрэн

/...../

Д.Баярмаа

/...../

Т.Ангирмаа

/...../

А.Уламбаяр

Нарийн бичгийн дарга

/...../

Ю.Буянхишиг

Батлав.Нийслэлийн түргэн Батлав.

тусламжийн төвийн захирал

Д. Дүрэвдаш



"Ирвэс секьюрити" ХХК

Гүйцэтгэх захирал

Т.Сэргэлэн

ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2016 оны 05 дугаар/
сарын 31ний өдөр

2016/02

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Нийслэлийн түргэн тусламжийн төв цаашид захиалагч гэх/, нөгөө талаас "Ирвэс секьюрити" ХХК /улсын бүртгэлийн №35/5774, регистрийн 2725401./ цаашид Хамгаалагч тал гэх/ Монгол Улсын Иргэний хууль болон Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийг удирдлага болгон дараах нөхцлүүдээр харилцан тохиролцож 2016 оны 06 сарын 01 өдрөөс 2016 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Хамгаалагч тал нь гэрээнд заасны дагуу Нийслэлийн түргэн тусламжийн төв хамгаалалтын алба хаагч / цаашид Хамгаалагч тал гэх/ ажиллуулан объектыг хамгаалах, Үйлчлүүлэгч тал ажил, үйлчилгээний хөлсийг төлөхтэй холбогдсон харилцааны үед үүсэх талуудын эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.2 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тохиолдолд талууд бичгээр саналаа солилцсоны үндсэн дээр гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажсанаар нэмэлт өөрчлөлт нь үндсэн гэрээний нэг адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

1.3 Энэхүү гэрээг 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс 2016 оны 12 дүгээр сарын 31-ний өдрийг дуустал байгуулав. Гэрээг сунгах, цуцлах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

1.4 Талууд бие биенийхээ хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хүндэтгэн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, үйл ажиллагааныхаа хүрээнд хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэлж, албаны нууцыг чанд сахих зарчмыг баримтлан хамтран ажиллана.

Хоёр. Гэрээний зүйл, үнэ

2.1 Гэрээний зүйл нь Үйлчлүүлэгч талын объект болох Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 5-н объект

Үүнд:

- СБД дахь Нийслэлийн түргэн тусламжийн төв 103
- СБД дахь Нийслэлийн түргэн тусламжийн төвийн авто бааз
- БЗД дахь 3-р төрхийн хажууд
- ХУД дахь яармаг салбар
- СХД дахь нэгдсэн эмнэлэг дахьт салбар тус тус

байх бөгөөд Хамгаалагч тал нь энэ нийт объектод 15 хамгаалагч ажиллуулна.

2.2 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр дахин өөр объектыг нэмж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн объект, түүний хамгаалалтын хүрээ, хязгаарын талаар болон түүнд ажиллуулах хамгаалагчийн орон тооны талаар тусгасан нэмэлт өөрчлөлтийг энэхүү гэрээний 1.2-т заасан нөхцлийн дагуу гэрээнд хавсаргана.

2.3 Үйлчлүүлэгч, хамгаалагч талын ажил үйлчилгээний хөлсийг сард 1 объектийн 1680000 /нэг сая зургаан зуун наян мянга/-н төгрөг, нийт 5 объектийн нэг сарын төлбөр болох 8400000 /найман сая дөрвөн зуун мянга/ төгрөгийг тухайн сар бүрийн сарын 8-ны дотор Голомт банк-н дахь манай 1102583841 тоот дансанд шилжүүлэх буюу бэлнээр төлнө.

Гурав. Захиалагч талын эрх үүрэг

3.1 Хамгаалагч талын үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар өөрийн ажилтнууд болон хамгаалагчидад холбогдох хууль тогтоомж болон байгууллагын дотоод журамтай холбогдсон шаардлага тавих

3.2 Хамгаалагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаа тохиолдолд зохих шаардлага тавих, энэ шаардлагыг биелүүлэхгүй удаа дараа гэрээний үүргийг зөрчсөн тохиолдолд гэрээг цуцлах талаар санал тавих

3.3 Хамгаалагчид объект болон ажил үүргийг нь танилцуулах, заавар зөвлөгөө өгөх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, дүгнэлт өгөх болон тэднийг өдөр дутмын удирдлагаар хангаж ажиллана.

3.4 Энэхүү гэрээний 4.2-д заасан шаардлагыг хангасан Хамгаалагчаар хамгаалуулахаар шаардах

3.5 Үйлчлүүлэгч болон тэдгээрийн ажилтнуудад хаанаас, хэнээс гэмт халдлага, хор аюул учруулж болзошгүй талаар сэжиг бүхий мэдээ, мэдээлэл авмагц Хамгаалагч талд нэн даруй мэдэгдэх, шаардагдах арга хэмжээг хамтран авах

3.6 Хамгаалуулагч тал / хамгаалагч/-ийн зүгээс гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар тавьсан албан ёсны санал, шаардлагыг тухай бүрт нь хүлээн авч шийдвэрлэх

3.7 Хамгаалагчийн ажиллах нөхцөл, ажиллах байр, тусгай хэрэгсэл хадгалах цоожтой сав, холбоогоор хангах

3.8 Хамгаалагчийн албан үүрэгтэй нь холбогдуулж шагнаж урамшуулах, энэ тохиолдолд хамгаалагч талд урьдчилан мэдэгдэнэ.

3.9 Хамгаалагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгийн хувьд хохирсон, гэмтэж бэртсэн тохиолдолд материаллаг дэмжлэг туслалцаа, тусламж үзүүлэх

3.10 Хамгаалалтын ажилтныг албан үүрэг гүйцэтгэхэд нь саад учруулах, хүлээсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүргийг гүйцэтгүүлэхгүй байх

Дөрөв. Үйлчилгээ үзүүлэгч талын эрх үүрэг

4.1 Гүйцэтгэгч талын үйл ажиллагааны үндсэн үүрэг нь объектод нэвтрэх хөдөлгөөнийг хянах, барилга, объект, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, гэмт хэрэг хэв журмын зөрчлөөс сэргийлэх, дэг журам сахиулах, ажиллагсдын аюулгүй байдлыг хангахад оршино.

4.2 Үйлчлүүлэгчийг 20 нас хүрсэн, эрүүл мэнд, бие бялдар ёс зүйн шаардлага хангасан зохих боловсрол, ажлын туршлагатай, холбогдох сургалтанд хамрагдсан, ял шийтгэл эдлэж байгаагүй хамгаалагчдаар хамгаалуулж, тэдгээрийг мэргэжлийн удирдлагаар хангах

4.3 Хамгаалагчдын ээлжийг зохицуулах, объект, түүний онцлог, хамгаалалтыг зохион байгуулах талаар үйлчлүүлэгч байгууллагатай харилцан мэдээлэл солилцож ажиллах

4.4 Мэдээллийг үндэслэн гарсан хэрэг, зөрчлийг таслан зогсоох, гэмт халдлага гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

4.5 Хамгаалалтын нөхцлийг сайжруулахад байнга санаачлагатай ажиллана.

4.6 Хамгаалалтын нөхцлийг сайжруулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцлийг арилгуулах талаар санал шаардлагыг үйлчлүүлэгч талд тавьж шийдвэрлүүлэх

4.7 Хамгаалагчдыг албан ёсоор томилж, тэдэнд энэхүү гэрээнд заасан ажил, үүргийг танилцуулах

4.8 Хамгаалалт, үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлт, гомдол, шаардлагыг тухай бүр хүлээн авч шийдвэрлэн хариу өгөх

4.9 Хамгаалагчийг тусгай төлөвлөгөө, хуваарийн дагуу албаны сургалт / эрх зүй, бие хамгаалах, гадаад хэл/-нд хамруулах

4.10 Хамгаалагчийг тусгай хувцас, зэвсэг техник / гав, бороохой, хийн буу,галт зэвсэг, газ, цахилгаан бороохой/ бусад шаардлагатай хэрэгслээр хангах

4.11 Хамгаалагчид тогтоосон цалин хөлсийг цаг хугацаанд нь олгож байх

4.12 Хамгаалагчтай байгуулсан гэрээний дагуу хариуцлага, сахилга, ажлын үр дүнг харгалзан гэрээг дүгнэж, цаашид ажиллуулах эсэхийг Үйлчлүүлэгч талын санал, үнэлгээг харгалзан шийдвэрлэж байх

4.13 Хамгаалагчдыг нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, хүн амын орлогын албан татварт хамруулах

4.14 Хамгаалагчийн хууль бус, илт буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарсан сөрөг үр дагаврыг хариуцах

4.15 Хамгаалж буй объектод халдах, амь нас, эрүүл мэндэд илт хохирол учруулж болох нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэмэгдэл хүчний туслалцаа үзүүлэх

4.16 Амралт баяр ёслолын өдөр болон ажлын бус цагаар тухайн байгууллагын зөвшөөрөлгүйгээр аливаа хүмүүсийг нэвтрүүлэхгүй байх

4.17 Ажил тарсны дараа бүх өрөө тасалгааны лац ломбо, галын аюулгүй байдал, зөвшөөрлийн системд үзлэг хийж илэрсэн дутагдлыг илтгэх хуудсаар Захиргаанд танилцуулж байх

4.18 Зэр зэвсэг, хорт бодис, согтууруулах ундааг дотогшоо нэвтрүүлэхгүйн тулд овор ихтэй ачаа тээш, сэжиг бүхий хүнийг саатуулан шалгаж байх

4.19 Биеийн байцаалт, бичиг баримтгүй, согтуу хөлчүү, ёс бус хувцасласан хэвийн бус хүмүүсийг объектод нэвтрүүлэхгүй байх

4.20 Хамгаалж буй объектод ус, цахилгаан, галын аюул болон бусад халдлага осол гарвал холбогдох байгууллага албан тушаалтанд шуурхай мэдэгдэх, гэмт үйлдлийн ул мөрийг хамгаалах, эзэн шалтгааныг олох, уг үйлдлийг таслан зогсоох арга хэмжээг өөрийн эрх мэдлийн хүрээнд авна.

4.21 Харуул хмагаалалтын ажилтан ээлжиндээ болсон үйл явдлын талаар рапорт бичиж, дараагийн ээлжийн харуулд хүлээлгэн өгөх ба рапортоо өглөө бүр нийслэлийн түргэн тусламжийн төвийн ээлжийн ахлагчид биечлэн мэдээлж шаардлагатай асуудлаар холбогдох арга хэмжээ авахуулах

Тав.Талуудын үйл ажиллагааны хязгаар

5.1 Талууд хамгаалалтын асуудлаас бусад асуудлаар бие биеийнхээ дотоод хэрэг, үйл ажиллагаанд оролцохгүй байх

5.2 Талууд бие биенийхээ хууль ёсны эрх, ашиг сонирхлыг харгалзан харилцан хүндэтгэж, хоёр байгууллагын болон хувь хүний нууцыг холбогдох хуулийн хүрээнд хамгаална.

5.3 Талууд нөгөө талын албан ёсны урьдчилан зөвшөөрөлгүйгээр тухайн байгууллагын талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөхгүй байх

5.4 Иргэд, хуулийн этгээдийн амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгийг аюултай байдалд хүрэхүйц үйл ажиллагаа явуулахгүй.

5.5 Үйлчлүүлэгч нь Монгол Улсын хуулийн эсрэг үйл ажиллагаа явуулахыг хамгаалагч талаас шаардах эрхгүй.

Зургаа. Маргааныг шийдвэрлэх болон бусад

7.1 Энэхүү гэрээнээс болон түүнтэй холбогдуулан гарч болзошгүй бүх маргаан, зөрчил буюу шаардлагыг талууд найрсагаар шийдвэрлэх арга

хэмжээг авах ба үүнд гэрээг биелүүлэх, зөрчих, зогсоох буюу хүчингүй болгох асуудлууд багтана. Хэрэв талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол бүх маргаан зөрчил буюу шаардлагыг Монгол Улсын хуулийн дагуу Шүүхийн байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

7.2 Энэхүү гэрээ болон Монгол Улсын холбогдох хуулиудад зааснаас бусад тохиолдолд энэхүү гэрээний нөхцлийг талууд дангаараа өөрчлөх болон энэхүү гэрээний үүргийг биелүүлэхээс дангаараа татгалзахыг хориглоно.

7.3 Аль ч тал албан ёсны урьдчилсан зөвшөөрөлгүй энэхүү гэрээгээр хүлээсэн өөрийн эрх, үүргээ хууль ёсны залгамжлагчаас бусад гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүй.

7.4 Энэхүү гэрээ нь талуудын гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр үйлчилж эхлэх ба гэрээний нөхцөл биелэгдсэнээр буюу гэрээ цуцлагдсанаар дуусгавар болно.

7.5 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, гарын үсэг зурж баталгаажуулсан ба талуудад нэг нэг хувь хадгалагдсан нь адил хүчинтэй болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

Нийслэлийн түргэн тусламжийн төв

Ахлах нягтлан бодогч



Б.Отгонтэнгэр

Утас: 98084807

Үйлчилгээ үзүүлэгчийг төлөөлж:

"Ирвэс секьюрити" ХХК-ний

Нягтлан бодогч



А.Баяржаргал

Утас: 88088301, 96659601